

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.02.26

2017 оны ажлаа дүгнүүлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 21 аймгаас шагналт 10 дугаар байранд орсон. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны А/38 тоот тушаалаар батлагдсан “Газрын харилцааны салбарын шилдгүүдийг шалгаруулах журам”-ын дагуу “Шилдэг ажил” төрөлд нэр дэвшин “Геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажил”-аар тэргүүн байранд шалгарчлолт амжилттай жил байлаа.

2018 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Барилгын хөгжлийн төв, аймгийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байна.

Газрын төлбөрийн орлого:

2017 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 90 сая төгрөг байсан бол 2018 онд 132 сая төгрөгөөр батлагдсан. Энэ нь нарны цахилгаан станцын зориулалтаар 2017 онд шинээр нэмж эзэмшүүлсэн газруудын төлбөр болон өмнөх оны газрын төлбөрийг тооцож авахаар төлөвлөсөн дүн юм.

Өнөөдрийн байдлаар 42.4 сая төгрөгийн төлбөр төвлөрөөд байна.

Газар өмчлөл, төлөвлөлт:

Шинээр газар өмчилсөн 117 иргэний газар өмчлөлийн материалыг хүлээлгэн өгч, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг авч баталгаажуулахыг зөвлөсөн.


2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумдын ИТХ-аар батлуулсны дагуу Сүмбэр сум болон Баянтал сумд газар өмчлөх өргөдлийг иргэдээс 2018 оны 01 дүгээр сарын 08-ний өдрөөс эхлэн авч, цахимаар /ЛМ програмаар/ бүртгэн ажилласан. Үүнд:

- Сүмбэр сум 504 иргэнд
- Баянтал суманд 127 иргэнд шинээр газар өмчлүүлэхээр өргөдөл хүлээн авч дууссан.

Шивээговь сумын тухайн жилийн төлөвлөгөө одоогоор батлагдаагүй байна.

Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт:

2018 онд 4 байршилд 3 удаагийн дуудлага худалдааг цахимаар зохион байгуулан ажиллаж 8,700,000 төгрөгийг орон нутгийн орлогын төсөвт төвлөрүүлээд байна. Дахин 1 ялагчаар 22 сая төгрөгийг төлүүлэхээр ялагчтай байгуулах гэрээг хийгээд хугацаа нь болоогүй хүлээгдэж байна.



Сүмбэр суманд 50 га газрыг нарны цахилгаан станцын зориулалтаар олгохоор төсөл сонгон шалгаруулалт зарлагдсан бөгөөд 2018 оны 03 дугаар сарын 22-нд шалгаруулалт явагдахаар хүлээгдэж байна.

Барилга, хот байгуулалт, оронсууц, нийтийнажахуй, барилгын материалын чиглэлээр:

- БХБЯ, БХТөв хамтран БНСУлсад зохион байгуулсан “Барилгын талбайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”-ны сургалтад БХБХэлтсийн дарга Б.Даваажаргал, ГУХэлтсийн дарга Б.Отгончимэг нар оролцсон.

Хот байгуулалтын чиглэлээр:

- Ариутгах татуургын өргөлтийн насос станц II-ын барилга холбох шугам сүлжээ,
- Аймгийн төвийн дугуйн зам
- Авто замын зургийг тус тус хянаж ХОХБТХэлтэст санал хүргүүлэн ажиллаж байна.
- Найрамдал хотхоны 3,8 дугаар байрны өмнөх тоглоомын талбайн ажлын төсөв тооцооллыг хамтран гаргасан. /50,0 сая төг/

Мэдээ тайлан:

- 2017 оны жижүүрийн хөтлөлтийн тайланг гаргаж ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн.
- Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр, “Шинэбүтээнбайгуулалт” дундхугацаанызорилтотхөтөлбөр, “Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр, “УС” үндэсний хөтөлбөр зэргийн биелэлтийг гарган ХОХБТХэлтэст хүргүүлсэн.
- Аймгийн Засаг дарга, БХТөвийн үр дүнгийн гэрээний төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.
- Нэгдсэн эмнэлгийн барилгын газардуулга, тоног төхөөрөмжийн газардуулгыг үзэж шалган мэдээллийг ЗДТГДаргад хүргүүлсэн.
- БХБЯаманд 2017 онд гүйцэтгэсэн ажил болон 2018, 2019 онд хийгдэх ажлын төлөвлөгөө судалгаа, төсөл хөтөлбөрөөр хийгдэх томоохон ажил, барилгын материалын үйлдвэрлэлийн талаарх ажлын судалгаа төлөвлөгөөг тус тус гарган хүргүүлсэн.

Барилга байгууламжид үзлэг хийж дараах ажилд “захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргах” ажилд ажилласан:

- Авто замын дагуух гэрэлтүүлгийн толгой солих ажлыг “Эс Жи Эм”ХХКомпани 17,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хийж гүйцэтгэсэн.



Захиалагчийн хяналтын ажил:

- Сүмбэр сумын нэгдсэн эмнэлгийн барилгын засварын ажлыг “Эс Жи Эм”ХХКомпани 59,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж байна. Ажил 2018.01.19-нд эхлэж 2018.02.19-ний байдлаар 90%-тай хийгдээд байна.



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР